

ИНТЕРНЕТ ОРЧИН ДАХЬ ГЭРЭЛ ЗУРГИЙН
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

Б. Баярмаа*

* Сэтгүүл зүйн магистр

Түлхүүр үг: Интернет орчин, гэрэл зураг, фото сэтгүүл зүй, зохиогчийн эрх

Хүн төрөлхтөн хэл яриа үүсэхээс өмнө хоорондоо мэдээлэл дамжуулдаг байсан дүрс, зургийн үнэ цэн өнөөдөр ч алдагдаагүй хэвээр байна. Ялангуяа гэрэл зураг гэдэг манай нийгэм, тэр дундаа мэдээллийн ертөнцийн чухал хэсэг боллоо. Гэрэл зургийг нэг талаас урлаг, нөгөө талаас шинжлэх ухаанд хамааруулан үздэг. Хүний харахуйн эрхтнээр дамжуулан төрүүлж буй тэр мэдрэмжээрээ урлагт тооцогдож байгаа бол мэдээлэл дамжуулдаг шинж чанараараа сэтгүүл зүйн шинжлэх ухаанд багтаж байна.

Фото сэтгүүл зүй бол үг ба зураг хэмээх хоёр хэрэгслийн холимог бөгөөд энэ хоёр элемент нь баримт мэдээллийг бидний мэдрэхүйн бүх эрхтнүүдэд хүргэж байдаг. Гэрэл зураг үүссэн цагаасаа эхлэн олон нийтэд мэдээлэл түгээх хэрэгсэл, сэтгүүл зүйн үйл ажиллагааны нэг хэлбэр болж ирсэн юм¹. Харин Интернет гэх орон зайд үл хязгаарлагдах, өнгө будгийг өндөр чанартайгаар хүргэж болох “хэрэгсэл” бий болсон нь гэрэл зургийн сэтгүүл зүйн хөгжлийг өндөр түвшинд хүргэсэн. Бид “National Geographic” сэтгүүлийн сайтаас байгаль дэлхийн

өвөрмөц өнгө төрхийг үзэн биширч, “Reuters” агентлагийн веб хуудаснаас дэлхийн нийтийн өдөр тутам болсон чухал үйл явдлыг фото зургаар мэдэж авч байна. Өдгөө гэрэл зураг гэдэг зах хязгааргүй далайд өсч үржиж буй загастай зүйрлэж болохоор болжээ. Интернет орон зайг мэдээлэл болон фото зургийг байгаа чигээр нь хадгалж, олон дахин ашиглаж болох агуулах гэж хэлж болно.

Дэлхийн хамгийн анхны гэрэл зургийг Францын иргэн Жозеф Нисефор Ньепс буулгаж түүхэнд мөнхөрсөн байдаг. Тэгвэл Интернет ертөнцөд гэрэл зургийг хамгийн анх нэвтрүүлсэн нь 1992 он юм. Женев дэх Европын цөмийн судалгааны байгууллага буюу CERN-ийн ажилтан залуу охидоос бүрдсэн “Les HorriblesCernettes” хамтлагийн зургийг хамгийн анх Интернетэд байршуулсан түүхтэй. Энэ зургийг Интернет сүлжээг бүтээгчдийн нэг Том Бернерс-Ли байршуулсан бөгөөд ингэхдээ фото шоп программаар дэвсгэр болон зарим хэсгийн өнгийг нь өөрчлөн gif өргөтгөлөөр хадгалсан байдаг². Интернет сүлжээг хамгийн анх цэргийн, дараа нь эрдэм шинжилгээний ажлын зориулалтаар ашиглаж байсан учраас Интернет дэх хамгийн анхны гэрэл зургийн түүх CERN (European

Organization for Research Nuclear) төвтэй ийнхүү холбогджээ. Энэ цагаас Интернет дэх мэдээ, мэдээллийг зураггүйгээр төсөөлөхийн аргагүй болж, фото зураг нь веб сайтын дизайны чухал бүрэлдэхүүн, агуулгыг дэмждэг зайлшгүй хэсэг нь болж хувирсан юм.

Тэгвэл гэрэл зураг Интернет, онлайн сэтгүүл зүйн ачаар хөгжил нь хурдасан ч зохиогчийн эрхийн асуудал нь дэлхийн өнцөг булан бүрт хөндөгдсөөр байгаа билээ. Олон улсын эрх зүйн системд зохицуулахад хамгийн түвэгтэй асуудлуудын нэг нь зохиогчийн эрхийн асуудал байдаг. Онлайн бүтээгдэхүүнийг хуулбарлахад хялбар, бага хугацаа зарцуулдаг, хяналт сул байдаг учраас гэрэл зурагчдын хувьд маш эмзэг талбар байсаар ирлээ. Олон улсад зохиогчийн эрхийг хамгаалахдаа 1971 онд баталсан Бернийн конвенцийг мөрддөг. Үүнд зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлүүдийг зааж өгсөн бөгөөд гэрэл зураг болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүтээл багтдаг. “Түүнтэй төсөөтэй аргаар туурвисан” гэдэгт фото эвлүүлэг, фото чимэг зэргийг ойлгож болох юм. Ж. Хартфилдийн үзэж байгаагаар “Техник арга хэрэгсэл гэхээсээ илүү, зорилгодоо хүрэхийн тулд эвлүүлэг хийдэг” аж³. Харин фото чимэгийг сонин сэтгүүлийн өнгө үзэмжийг сайжруулах, нийтлэлийг уншихад дөхөм болгох зорилгоор хийдэг юм⁴. Тодруулбал, гэрэл зурагчны авсан фото зургаас гадна компьютерийн аргаар хийсэн эвлүүлэг, фото чимэг хүртэл зохиогчийн эрхтэй гэж ойлгож болох юм.

Гэсэн ч дээрх конвенцид Интернет орчинд хэрхэн мөрдөх тухай зохицуулалт байхгүй тул 2002 онд “Дэлхийн оюуны өмчийн байгууллагын зохиогчийн эрхийн асуудлаарх гэрээ”-г баталсан байна⁵. Мөн судлаач Роберт

Б.Гелман НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын цахим орчин дахь хувилбар болох “Цахим орон зай дахь Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг боловсруулсан байдаг. Уг тунхаглалын 17 дугаар зүйлд “Хэн бүхний хувийн мэдээлэл, онлайн үйл ажиллагаа нь хувийн өмч бөгөөд түүнийг тухайн этгээд өөрөө хянана. Хүн бүр өмчөө үнэлж, ил болгох, солилцох эсэхээ шийдэх эрхтэй” гэсэн байдаг. Энэ өнцгөөс авч үзвэл тухайн хүн өөрийн авсан зургаа Интернет орчинд байрлуулах үйл явц нь онлайн үйл ажиллагааны нэг хэлбэр болох бөгөөд үүнийг бүтээгч нь өөрийн өмч хэмээн үзэж, үнэлж, ил болгож, солилцох эрхтэй юм.

Интернетэд байршсан зураг гэдэг хэн дуртай нь барьж болдоггүй “загас” юм. Ихэнхи Интернет хэрэглэгчид, тэр дундаа сэтгүүлчид “Гүүгл”-ийн санд хадгалагдаж байгаа зургийг хэн дуртай нь хэрэглэж болно гэсэн ташаа бодолтой байдаг. Цаашлаад твиттер хуудас, инстаграмдаа зургаа оруулсан л бол тэр нь олон нийтийн эзэмшилд очно гэсэн ойлголттой байх нь элбэг. Тэгвэл энэ нь тун эндүү ойлголт юм. Зураг онлайн орчинд байх, олон нийтийн эзэмшилд байх (in public domain) гэдэг нь хоёр тусдаа зүйл гэдгийг ялгаж, салгах нь зүйтэй. Гэрэл зураг бусад зохиогчийн эрх бүхий бүтээлүүдийн адил бүтээгдсэн цагаасаа эхлэн автоматаар зохиогчийн эрхээр хамгаалагддаг. Олон нийтийн сайт, сүлжээнд тавигдлаа гээд зохиогчийн эрхтэй байх үндсэн шинж чанараа алддаггүй. Нэг жишээ дурдахад, 2011 онд BBC агентлаг Тотенхамын үймээний зургийг нийтлэхдээ хэн нэгэн зурагчин, эзэмшигчийн нэргүйгээр зөвхөн “твиттер”-ээс гэсэн тайлбар бичжээ. Сэтгүүлч

Энди Маббетт энэ тухай өөрийн блогтоо тайлбарлан бичихдээ “Твиттерт нийтлэгдсэн бүх контент зохиогчийн эрхэд хамаарахгүй. Учир нь тэр контент олон нийтийн өмч болсон” гэжээ. Энэ бол олон нийтийн нийтлэг, буруу хандлагын жишээ юм. Энди Маббеттын энэ тайлбарыг мэргэжлийн хүмүүс ихэд шүүмжилсэн байдаг. Сошиал сайтад нийтлэгдсэнээр уг гэрэл зургийн үндсэн эрх алга болдоггүй.

Хэрэв бид Интернетээс хууль зөрчихгүйгээр гэрэл зураг ашиглая гэвэл тухайн зургийг эзэмшигчээс зөвшөөрөл авах ёстой. Гэрэл зургийг ашиглах зөвшөөрлийг “royalty free”, “right managed” гэж хоёр ангилж үздэг. “Royalty free” гэдэг нь тухайн гэрэл зургийг ашиглах зөвшөөрлийг нэг л удаа авдаг бөгөөд ямар ч хэлбэрээр (хууль зөрчихөөс бусад), хэдэн ч удаа ашигласан дахин нэмэлт төлбөр авдаггүй. Харин “right managed” гэдэг нь гэрэл зургийг ашиглах эрх авсан ч хугацаа, газар зүйн бүс, нийгмийн салбар гэх мэтээр тодорхой хэмжээний хязгаарлалттайгаар ашиглана гэсэн үг юм. Зөвшөөрөл авахдаа хийсэн гэрээнд зааснаас өөрөөр ашиглахыг хүсвэл нэмэлт төлбөр төлөх, дахин гэрээ хийх хэрэгтэй болно.

Олон нийтийн дунд “Хэрэв зургийг арилжааны зорилгоор биш, зөвхөн хувийн блогтоо ашиглах бол төлбөр төлөх, зөвшөөрөл авах шаардлагагүй биз дээ?” гэсэн эргэлзсэн асуулт байдаг. Тэгвэл үүнд дээр дурдсаны адил заавал зохиогчийн эрхийг нь хүндэлж, зөвшөөрөл авах ёстой. Тэр байтугай зарим оронд архитекторын өвөрмөц бүтээл, барилгын зургийг авахад тусгай зөвшөөрөл шаарддаг. Жишээ нь бид л хууль зөрчин хуулбарлан хэрэглэж байгаагаас биш

Сиднейн дуурийн театрын зургийг авахад тодорхой хэмжээний зөвшөөрөл авах ёстой. Мөн ямар нэг барилга, эсвэл түүхийн чухал олдворын зургийг Интернетээс хайгаад олохгүй бол тухайн объектын зургийг олон нийтэд дэлгэхийг хориглосон байх магадлалтай юм.

Фото зургийн зохиогчийн эрхийн зөрчлийг дараах хэлбэрээр авч үзэж болох юм. Үүнд,

- Зургийг зөвшөөрөлгүйгээр бүхлээр нь ашиглах,

- Зарим хэсгийг зөвшөөрөлгүй ашиглах,

- Гэрээнд зөвшөөрснөөс өөр хэлбэрээр ашиглах,

- Хувиргах,

- Тухайн зургийн өнцөг, объектыг яг дуурайлган дахин авах зэрэг болно. Бусдын гэрэл зургийг бүхлээр нь ашиглах зөрчил хамгийн их гардаг бол тухайн зургийг тасдах, өөр зурагтай эвлүүлэн ашиглах нь мөн дутахгүй элбэг байна. Харин зургийн өнцөг, объектыг яг дуурайлган дахин авах нь өмнөх хоёр хэлбэртэй харьцуулахад цаг хугацаа, хөдөлмөр шаарддаг тул арай цөөн тохиолдож байгаа ч ийм зөрчлийг Интернет орон зайгаас түвэггүй олно.

Монгол Улсын хууль тогтоомжид Интернет орчин дахь гэрэл зургийн асуудлыг хэрхэн зохицуулсан байдаг талаар дурдъя. Монгол Улсын Үндсэн хуульд хүн бүр чөлөөтэй хэвлэх, нийтлэх эрхтэй гэж заасан байдаг бөгөөд үүнд гэрэл зургийг нийтлэх эрх багтана. Мөн Зохиогчийн эрхийн тухай болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлд гэрэл зургийг оруулсан байдаг. Тодруулбал, 7.1.8-д гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээлийг өөрийн

болон зохиомол, нууц нэрээр эсхүл нэргүйгээр нийтлэх эрхтэй гэж заасан байна.

Монголын хууль эрх зүйн орчны хүрээнд дараах Интернет орчин дахь гэрэл зургийн зохиогчийн эрхийн асуудлыг тусгайлан заасан, дурдсан эрх зүйн бичиг баримт алга. Гагцхүү Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд “Интернетэд зохиогчийн эрхийг хамгаалах” гэсэн зүйлд ерөнхий заалт оруулжээ. Үүнд,

25.1. Интернетийн үйлчилгээ түгээгч нь өөрийн серверт байршуулсан веб хуудсанд зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогч болон эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй.

25.2. Интернетийн үйлчилгээ түгээгч нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн веб хуудсыг хаах үүрэг хүлээнэ⁶ гэжээ. Эдгээр заалт нь веб сайтыг эрхлэн гаргагч нь зохиогчийн эрхийн зөрчилтэй гэрэл зургийг гаргахгүй байх, хэрэв тийм зураг нийтлэгдсэн бол арга хэмжээ авах ёстой гэдгийг заасан байна. Гэвч энэ заалт гэрэл зургийн зохиогчийн эрхийн хувьд хэрэгжихгүй байгаа юм. Учир нь Монголд Интернет орчинд гэрэл зургийг хэрхэн хууль ёсны дагуу ашиглах ёстой талаар төдийлөн анхаардаггүй. Зохиогчийн эрх зөрчиж байна гэдгээ мэддэггүй нэлээд хэсэг байхад, мэдсэн ч хэрэгжүүлдэггүй нэг хэсэг бас байна.

Монголын онлайн сэтгүүл зүйн хүрээнд гэрэл зургийн зохиогчийн эрхийн зөрчил элбэг. Веб сайт, сонины эрхлэгчид “Гүүгл”-ээс татсан зургийг бүрэн эрхтэй мэтээр хэрэглэж байгаа бол хэрэглэгчид сошиал сайт, блогтоо мөн л дур зоргоороо ашиглаж байгаа. Харин цөөн тооны дотоодын гэрэл зурагчдын бүтээлийн асуудал л энэ хүрээнд яригдаж байна. Тухайлбал 2011 онд МАХН-ын дарга Н.Энхбаярыг баривчлах үеэр түүнийг цагдаа нар өргөж, гэрээс нь гаргаж байгаа фото

зураг олныг шуугиулсан. Энэ зураг бол shuud.mn сайтын гэрэл зурагчин Ариунцэцэгийн бүтээл. Зураг дээр shuud.mn сайт өөрийн логог тавьсан байсан ч цөөнгүй сайт хуулбарлаж, зарим нь логог нь арилгаж нийтэлсэн байдаг. Нэг сайт эзэмшигчийн логог арилгаад зог-

сохгүй өөрийн сайтын логог тавьсан тохиолдол гарсан юм. Иймэрхүү зөрчил Монголын онлайн сэтгүүл зүйд хэвийн үзэгдэл шахуу болжээ. Ингэж даамжрах болсон шалтгаан нь Интернет хэрэглэгч, сэтгүүлчдийн дунд гэрэл зургийн зохиогчийн эрхийн тухайн ойлголт хомс, түүнийг үл тоомсорлодогтой холбоотой. Нөгөө талаас зохиогчид нь өөрсдөө гомдол гаргадаггүй, гаргасан ч тэрүүхэн тэндээ зохицоод өнгөрдөг. Монголд зохиогчийн эрхийн асуудлыг Оюуны өмчийн газар хариуцан ажилладаг. Харин Оюуны өмчийн газарт төлөвлөгөөнд орсон эсвэл, хэн нэгэн гомдол гаргасан тохиолдолд л шалгадаг учраас онлайн



Монголд Интернет орчин дахь гэрэл зургийн зохиогчийн эрхийн асуудлыг тусгайлан заасан, дурдсан эрх зүйн бичиг баримт алга. Гагцхүү Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд “Интернетэд зохиогчийн эрхийг хамгаалах” гэсэн зүйлд ерөнхий заалт оруулжээ







мэдээллийн хэрэгсэл гэрэл зураг хуулбарласныг шийдвэрлэсэн тохиолдол тус байгууллагад бүртгэгдээгүй байна.

Ийнхүү Интернет орчинд гэрэл зургийн зохиогчийн эрх зөрчил гаарч, түүнийг зохицуулахад хүндрэлтэй байна. Гэрэл зургийн зохиогчийн эрхийг хэрхэн хангаж ажиллах вэ гэдэг нь онлайн хэвлэлд ажиллаж буй хүмүүсийн мэдвэл зохих ёстой асуудал. Тэгвэл хэрхэн, яаж?

Дэлхийн жишгээр бол зохиогч нь тухайн бүтээлийг бусад хүмүүс ашиглаж болно, эсвэл болохгүй гэсэн тэмдэглэгээ хэрэглэдэг. Барууны орнуудад сүүлийн жилүүдэд Интернет дэх зохиогчийн эрх бүхий бүтээлийг CC (creative commons) гэж тэмдэглэх болжээ. Интернет дэх эх сурвалжийг

бүтээлчээр ашиглах гэдэг утгаар нь “creative commons” буюу “оюуны бүтээлч хамтын өмч” гэж нэрлэдэг. Энэ эрхийг орон бүр өөрийн хэл дээр хуулийн хэллэгээр томъёолж бичдэг⁷. Зурагчин тухайн бүтээлийг бүхлээр нь ашиглаж болох, хэсэгчлэн ашиглаж болох, эсвэл бизнесийн зорилгоор хэрэглэж болохгүй, уг бүтээлийг ашиглаж болохгүй гэх зэргээр нөхцлүүдээ заасан тэмдэглэгээг гэрэл зураг дээрээ тавина. Хэрэглэгч тухайн тэмдэгтийг уншиснаар хууль зөрчихгүйгээр хэрхэн ашиглаж болохоо мэдэж авна. CC эрх авахыг хүсвэл creativecommons.org хаягаар орж, тохирох эрхийг зааж өгснөөр шаардлагатай эх кодыг гарган авч, өөрийн веб хуудастай холбоно. Энэ тэмдэглэгээг зөвхөн гэрэл зурагт биш бусад мэдээ, мэдээлэлд ч ашигладаг.

тэмдэг	Товчилсон хэлбэр	Нэршил	Тайлбар
	by	Нэрийг заах (англиар: Attribution)	Зохиогчийн нэрийг дурьдах
	nc	Ашгийн бус (Non-Commercial)	Уг бүтээлийг бизнесийн зорилгоор хэрэглэж болохгүй
	nd	Боловсруулахгүй (No Derivatives)	Уг бүтээлийг өөрчилж болохгүй.
	sa	Ижил нөхцөлөөр цааш дамжуулах (Share Alike)	Уг бүтээлийг өөрчилсөн ч мөн л урьдын адил эрхтэй байлгах.

Зураг 1. “Creative commons” тэмдэглэгээний тайлбар

Монголд “Creative commons” тэмдэглэгээг нэвтрүүлэх зорилгоор www.creativecommons.mn сайтыг нээсэн ч үүнийг хэрэглэж хэвшээгүй байна. Дэлхийн нийтээр фото сэтгүүл зүйн мэргэжилтнүүд “Creative commons”-ийг хэрэглэх нь Интернет орчинд ойлголцох хамгийн зөв шийдэл хэмээн үзэж, олон оронд төсөл хэрэгжүүлж байгаа юм. Гэвч энд бас нэгэн ойлгомжгүй асуудал гарч ирнэ. Нэгэнт дэлхийн

даяар “Creative commons” тэмдэглэгээг хэрэглэж заншаагүй, ийм тайлбартай зураг туйлын ховор байхад хэрхэн зохицох вэ гэдэг асуудал. Үүнийг практикт хэрхэн зохицуулж байгаа талаар дурдъя.
















- “Гүүгл”, “фликр” зэрэг сайтуудаас зохиогчийн эрхтэй зургуудыг татаж хэрэглэх. “Гүүгл”-ээс зохиогчийн эрхтэй гэрэл зургийг хайхдаа зургийн хайлтын хэсэгт түлхүүр үгээ бичиж хайна. Үр

дүн нь гарч ирэхэд “Search tools” гэсэн хэсэг дээр дарахад “usage rights” буюу зохиогчийн эрхтэй, зөвшөөрөл авч болохуйц зургууд гарч ирнэ. Харин “Фликр”-ын хувьд мөн түлхүүр үгээрээ хайлт хийх бөгөөд үр дүн гарч ирэхэд “advanced search” гэсэн хэсгээс “only search with in Creative Commons licensed content” буюу зөвхөн CC тэмдэглэгээтэй контент гэсэн хэсгийг сонгон хэрэглэнэ.

- Morgue File, PixaBay зэрэг үнэгүй сайтуудаас олон нийтийн эзэмшил болсон зургийг татаж авах. Гол нөхцөл нь татаж авсан зургаа ямар зорилгоор, хэрхэн ашигласан бэ гэдгээ эргэн мэдээлдэг байх юм.

- Гэрэл зурагчид, бүтээгчид зохиогчийн эрхээ хамгаалахдаа зураг дээрээ усан тамга тавих, гарын үсэг, нэрээ бичих, зургийн гол хэсэгт тамгалах зэрэг механик аргуудыг өргөн хэрэглэдэг.

- Гэрэл зураг худалддаг тусгай сайтуудаас худалдаж авах. Одоогийн байдлаар Монголд “Cosmopolitan” сэтгүүл гэх зэрэг цөөн хэдэн байгууллага л чухал гэрэл зургуудыг гадны сайтуудаас худалдан авч хэрэглэж байна. Мөн зарим сайтууд tra.mn сайттай гэрээ хийж, албан ёсны логотой зургийг нь их, бага хэмжээгээр ашиглаж байгаа эерэг хандлага байгааг дурдахгүй өнгөрч болохгүй.

Creative Commons CC	Үүнийг ашгийн зорилгоор хэрэглэж болох уу?	Үүнийг шинэ бүтээл хийхдээ ашиглаж болох уу?
Зохиогчийн нэрийг дурлах (Attribution) 		
- Зохиогчийн нэрийг дурлах - Үг бүтээлийг оорилсон ч урьдын адил эрхтэй байлгах (Share Alike) 		Болов, гэхдээ шинэ бүтээлдээ “Share Alike” эрх авна.
- Зохиогчийн нэрийг дурлах - Үг бүтээлийг оорилж болохгүй (No Derivatives) 		
- Зохиогчийн нэрийг дурлах - Үг бүтээлийг бизнесийн зорилгоор хэрэглэж болохгүй (Non-Commercial) 		Болов, гэхдээ шинэ бүтээлээрээ ашиг олж болохгүй, тухайн бүтээлдээ ашгийн бус байх эрх авна.
- Зохиогчийн нэрийг дурлах - Үг бүтээлийг бизнесийн зорилгоор хэрэглэж болохгүй - Үг бүтээлийг оорилсон ч урьдын адил эрхтэй байлгах (Non-Commercial, Share Alike) 		Болов, гэхдээ шинэ бүтээл нь ашгийн бус байна, мөн бүтээлдээ “Share Alike” эрх авна.
- Зохиогчийн нэрийг дурлах - Үг бүтээлийг бизнесийн зорилгоор хэрэглэж болохгүй - Үг бүтээлийг оорилж болохгүй (Non-Commercial, No Derivatives) 		

Зураг 2. Гэрэл зургийг ашгийн зорилгоор, эсвэл шинэ бүтээлдээ ашиглаж болох эсэх талаарх тайлбар

Гэрэл зураг гэдэг бол бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн. Тиймээс ч зохиогч, бүтээгч нь түүнийг өмчлөх нь зүй ёсны хэрэг юм. Харин Интернет орчинд энэ зүй ёсны эрх нь зөрчигдөж байгааг зогсоохын

тулд эхний ээлжинд гэрэл зурагчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрсдөө дээрх CC тэмдэглэгээг анхлан хэрэгжүүлж, цаашид олон нийтийн хэрэглээ болгох боломж, бололцоо бүрэн бий билээ. Мөн Интернет хэрэглэгч-

дийн зохиогчийн эрхийн талаарх ойлголтыг зөв чиглүүлж, хууль ёсны хэрэглээнд сургахад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд түүчээлэн оролцох нь зүйтэй.

Ишлэл

¹ *Норовсүрэн Л.* 2012. Фото сэтгүүл зүй. УБ., 19 дэх тал.

² <http://www.wikipedia.org>

³ *Норовсүрэн Л.* Дурд. зох., 282 дахь тал.

⁴ Мөн тэнд, 296 дахь тал.

⁵ Оюуны өмчийн газар. 2010. Уран бүтээлчээс олон нийтэд. УБ., 25 дахь тал.

⁶ <http://legalinfo.mn>

⁷ <http://creativecommons.mn>

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. www.wikipedia.com

2. www.creativecommons.mn

3. www.legalinfo.mn

4. www.macworld.co.uk

5. *Норовсүрэн Л.* 2012. Фото сэтгүүл зүй. УБ.

6. *Болд-Эрдэнэ Б.* 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.

7. 2009. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №10.

8. 2010. Оюуны өмчийн газар. Уран бүтээлчээс олон нийтэд. УБ.

Resume

This article is about legal copyright issues of photos in the internet environment. In the article, International documents and Mongolian legal documents related to the photo copyright are studied and in addition copyright infringements, its types, methods to solve it, and practical experiences are mentioned.